ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХОВД ХӨШӨӨТ ХӨГЖИЛ САНГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/36/СТА-ОНТС**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Ховд хот<br>2021 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхтулга<br>Утас: 70432545<br>цахим хаяг: Bataa0119@yahoo.com |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.* м

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТТЗ* | *Төсвийн төвлөрүүлэн захирагч* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |

## Агуулга


1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ....5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр ....5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр ....6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН төгрөгөөр ....7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ....8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН ....8
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН ...**Error! Bookmark not defined.**
3.АУДИТЫН ТАЙЛАН ....10
3.1. Ерөнхий зүйл ....10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....10
3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ ....11
3.4. Материаллаг байдал ....11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....12
3.7. Шилэн дансны мэдээлэл ....13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....13
3.9. Аудитын илрүүлэлт ....14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....14
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ ....14
1. Зардлын данстай холбоотой асуудал ....**Error! Bookmark not defined.**
2. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал ....14
3. Худалдан авалттай холбоотой асуудал ....**Error! Bookmark not defined.**
4. Өөрийн орлоготой холбоотой асуудал ....**Error! Bookmark not defined.**
5. Худалдан авалттай холбоотой асуудал ....**Error! Bookmark not defined.**
6. Бараа материалтай холбоотой асуудал ....**Error! Bookmark not defined.**
7. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал ....**Error! Bookmark not defined.**
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ ....14

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

_____________ № _____________

танай _____________ -ны № _____________ -т

ХӨШӨӨТ ХӨГЖИЛ САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Т.МЯГМАРДОРЖ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөшөөт хөгжил сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөшөөт хөгжил 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанар зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **179,913,199.98** | **121,449,731.78** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 67,055,718.08 | 7,636,393.88 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 67,055,718.08 | 7,636,393.88 |
| **3121** | **Төгрөг** | 67,055,718.08 | 7,636,393.88 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 67,055,718.08 | 7,636,393.88 |
| **33** | **АВЛАГА** | 110,145,287.90 | 109,668,287.90 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 477,000.00 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 68,568,287.90 | 68,568,287.90 |
| **335** | **Бусад авлага** | 41,100,000.00 | 41,100,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 41,100,000.00 | 41,100,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 1,210,194.00 | 1,231,700.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 1,210,194.00 | 1,231,700.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,502,000.00 | 2,913,350.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 1,502,000.00 | 2,913,350.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 367,000.00 | 637,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 779,000.00 | 2,275,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 356,000.00 | - |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | - | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,917,799.85** | **6,924,433.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,917,799.85 | 6,924,433.05 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,824,049.87 | 6,143,183.11 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 7,999,800.00 | 9,979,800.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (4,075,000.04) | (5,816,200.04) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,450,000.00 | 3,950,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,550,750.09) | (1,970,416.85) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,093,749.98 | 781,249.94 |
| 39301 | Програм хангамж | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (156,250.02) | (468,750.06) |
| **394** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **186,830,999.83** | **128,374,164.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **10,522,690.08** | **10,570,902.43** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 10,522,690.08 | 10,570,902.43 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,170,946.69 | 2,215,059.04 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 4,100.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 8,351,743.39 | 8,351,743.39 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,711,733.39 | 7,711,733.39 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 640,010.00 | 640,010.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **176,308,309.75** | **117,803,262.40** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 176,308,309.75 | 117,803,262.40 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | - |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 176,308,309.75 | 117,803,262.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 176,308,309.75 | 176,308,309.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (58,505,047.35) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **186,830,999.83** | **128,374,164.83** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1128354970.67** | **1579251489.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1128354970.67** | **1579251489.23** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1128354970.67 | 1579251489.23 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1128354970.67 | 1579251489.23 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1128354970.67 | 1254146996.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0.00 | 325104493.23 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1306570742.89** | **1637756536.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **124152128.89** | **59119506.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 117602128.89 | 51869506.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 24690790.00 | 30609166.00 |
| 210101 | Үндсэн цалин | 24690790.00 | 26914523.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 2390643.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 1304000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3086348.67 | 4036145.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2098717.11 | 2744579.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 246907.89 | 322891.66 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 197526.28 | 258313.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 49381.61 | 64578.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 493815.78 | 645783.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2795907.00 | 3806528.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 549300.00 | 671750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1405835.00 | 2451000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 504772.00 | 515978.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 156000.00 | 156800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 40000.00 | 11000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 140000.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2521500.00 | 2259300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1367500.00 | 1791000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1154000.00 | 468300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 81801666.40 | 5500000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79301666.40 | 3000000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100000.00 | 100000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2400000.00 | 2400000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2705916.82 | 5658366.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1030000.00 | 3185000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1675916.82 | 2473366.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6550000.00 | 7250000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6550000.00 | 7250000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6550000.00 | 7250000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1182418614.00** | **1578637030.20** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1182418614.00 | 1578637030.20 |
| 220001 | Барилга байгууламж | 76718137.00 | 299910166.00 |
| 221001 | Их засвар | 164462543.00 | 803944644.20 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 579163402.00 | 296849000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 362074532.00 | 177933220.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0.00 | 0.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-178215772.22** | **-58505047.35** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 0.00 | 0.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 0.00 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | 0.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-178215772.22** | **-58505047.35** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,257,189,796.91** | **1,292,026,996.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,257,189,796.91** | **1,292,026,996.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,257,189,796.91 | 1,292,026,996.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,257,189,796.91 | 1,292,026,996.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,257,189,796.91 | 1,292,026,996.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **127,228,693.40** | **58,042,371.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **127,228,693.40** | **58,042,371.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **120,678,693.40** | **50,792,371.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 24,690,790.00 | 30,542,898.00 |
| 210101 | Үндсэн цалин | 24,690,790.00 | 27,040,642.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 2,117,812.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 1,384,444.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,094,030.00 | 1,903,675.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,106,398.44 | 1,136,039.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 246,907.89 | 71,568.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 197,526.28 | 57,255.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 49,381.61 | 14,313.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 493,815.78 | 624,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,413,907.00 | 3,694,798.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 553,900.00 | 770,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,761,835.00 | 1,818,020.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 504,772.00 | 749,978.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 156,000.00 | 156,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 205,000.00 | 200,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 232,400.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 2,680,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 200,000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 2,480,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,998,500.00 | 2,009,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,844,500.00 | 1,309,900.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,154,000.00 | 700,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 81,801,666.40 | 5,261,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79,301,666.40 | 2,761,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000.00 | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,679,800.00 | 4,700,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,679,800.00 | 4,700,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,550,000.00** | **7,250,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,550,000.00 | 7,250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,550,000.00 | 7,250,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,129,961,103.51** | **1,233,984,625.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,251,998,766.00** | **1,293,403,949.20** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,251,998,766.00** | **1,293,403,949.20** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,251,998,766.00 | 1,293,403,949.20 |
| 220001 | Барилга байгууламж | 98,208,508.00 | 299,910,166.00 |
| 221001 | Их засвар | 172,567,752.00 | 518,711,563.20 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 582,763,402.00 | 296,849,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 398,459,104.00 | 177,933,220.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,251,998,766.00)** | **(1,293,403,949.20)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (122,037,662.49) | (59,419,324.20) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 189,093,380.57 | 67,055,718.08 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 67,055,718.08 | 7,636,393.88 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | 354,524,081.97 | | 354,524,081.97 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | **354,524,081.97** | - | 354,524,081.97 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | (178,215,772.22) | | (178,215,772.22) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | **176,308,309.75** | - | 176,308,309.75 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | **176,308,309.75** | - | 176,308,309.75 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | **176,308,309.75** | - | 176,308,309.75 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | (58,505,047.35) | | (58,505,047.35) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | **117,803,262.40** | - | 117,803,262.40 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2308300000.00 | 1351446320.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 63965600.00 | 58042371.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 56715600.00 | 50792371.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 31226480.00 | 30542898.00 |
| 210101 | Үндсэн цалин | 27331280.00 | 27040642.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2277600.00 | 2117812.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1617600.00 | 1384444.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4215570.00 | 1903675.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2966520.00 | 1136039.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 312260.00 | 71568.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 249810.00 | 57255.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 62450.00 | 14313.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 624530.00 | 624500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3695550.00 | 3694798.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 770000.00 | 770000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1818750.00 | 1818020.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 750,000.00 | 749,978.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 156,800.00 | 156,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 200,000.00 | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,980,000.00 | 2,680,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 200,000.00 | 200,000.00 |
| 210602 | Тавилга | 2,480,000.00 | 2,480,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,398,000.00 | 2,009,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,898,000.00 | 1,309,900.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,500,000.00 | 700,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,500,000.00 | 5,261,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,000,000.00 | 2,761,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000.00 | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,700,000.00 | 4,700,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,700,000.00 | 4,700,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,250,000.00 | 7,250,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,250,000.00 | 7,250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,250,000.00 | 7,250,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,244,334,400.00** | **1,293,403,949.20** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,244,334,400.00 | 1,293,403,949.20 |
| 220001 | Барилга байгууламж | 666,000,000.00 | 299,910,166.00 |
| 221001 | Их засвар | 833,000,000.00 | 518,711,563.20 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 512,100,000.00 | 296,849,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 233,234,400.00 | 177,933,220.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,308,300,000.00 | 1,292,026,996.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,308,300,000.00 | 1,292,026,996.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,308,300,000.00 | 1,292,026,996.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | **67,055,718.08** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | **7,636,393.88** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 3.00 | 3.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2.00 | 2.00 |

## 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. Ерөнхий зүйл

Ховд хөшөөт хөгжил сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ховд хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал Т.Мягмардорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ховд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж нийгмийн салбарын хөгжлийг дэмжих, байгаль орчныг хамгаалахад аймгийн нутаг дэвсгэрт баялаг ашиглагчийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах зорилгыг хангах биелүүлэхийн тулд дараах үйл ажиллагааны чиглэлийн дагуу хөрөнгө оруулалт арга хэмжээг санхүүжүүлж байна.

Үүнд:

1. Аймгийн болон нөлөөллийн сумдын дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх;
2. Үйлдвэрлэл, Үйлчилгээ, Хөдөө аж ахуйн салбарын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих;
3. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх;
4. Нийгэм, соёлын салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
5. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
6. Аймгийн ИТХ, Засаг даргаас дэмжсэн бусад асуудлууд

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 140 тоот тогтоол “ Нийгмийн даатгалын шитгэлээс чөлөөлж ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

. *Засгийн газрын*

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Ховд Хөшөөт хөгжил сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй. Харин аймгийн төрийн сангаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1435088.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 14350.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1579251.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 15792.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд хөшөөт хөгжил сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58456.7 мянган төгрөгөөр буюу 31 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 67055.7 | 7636.4 | (59419.3) |
| АВЛАГА | 110145.3 | 109668.3 | (477.0) |
| Урьдчилж гарсан зардал | 1210.2 | 1231.7 | 21.5 |
| БАРАА МАТЕРИАЛ | 1502.0 | 2913.4 | 1411.4 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 6917.8 | 6924.4 | 6.4 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **186830.9** | **128374.2** | **(58456.7)** |
| Нийт өр төлбөр | **10522.7** | **10570.9** | **(48.2)** |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | **176308.3** | **117803.3** | **(58505.0)** |
| Хуримтлагдсан үр дүн | **176308.3** | **117803.3** | **(58505.0)** |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **186830.9** | **128374.2** | **(58456.7)** |

Мөнгөн хөрөнгө данс 59419.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд аймгийн ИТХ-аар баталсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт арга хэмжээг санхүүжүүлсэн мөн Ковид-19 цар тахалтай холбоотой, МоЭнКо ХХК-ны нүүрсний экспорт буурч зогсонги байдалтай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэл 1411.4 мянган төгрөг

болж өссөн нь тайлант онд бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл: оны эхэнд 110145.3 мянган төгрөгийн авлагатай тайлант онд 30000.0 мянган төгрөгийн Ковид-19 цар тахалтай холбоотой мах хөтөлбөрийн авлага нэмэгдэн буцаан төвлөрүүлж, ажиллагчидтай холбоотой томилолтын авлагыг суутган барагдуулж оны эцэст 109668.0 мянган төгрөгийн авлагатай байна Уг авлагыг эзэн холбогдогчоор нь задлавал 2014 онд хэрэгжсэн нүүрс хөтөлбөрийн хүрээнд Ховд аймгийн ЗДТГ-тай МоЭнКо ХХК байгуулсан гэрээний дагуу хөнгөлөлттэй зээлийг аймагт олгон олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийг санд төвлөрүүлэх хөрөнгөнөөс суутган тооцсонтой холбоотой 68568.3 мянган төгрөг, 2015 онд мах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдэл Нью зест ХХК-тай холбоотой 26100.0 мянган төгрөг, Нүүрс хөтөлбөрийн хүрээнд ЗДТГ-т олгосон зээл 15000.0 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6917.8 мянган төгрөг, оны эцэст 6924.4 мянган төгрөг болж 48.2 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд 2480.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, ширээг орлогод хүлээн авч тайлант хугацаанд 2473.3 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн данс 10522.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлант онд 1650773.5 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж 1650725.3 мянган төгрөгийг өглөг хасагдаж 10570.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өр төлбөрийн задалбал Хөшөөт хөгжил сангийн өмнөх захирал С.Амарсайханд өгөх цалингийн өглөг 2170.8 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл хөгжлийн газарт Хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах төвийн тохижилтын ажилд 1951.3 мянган төгрөг, Олзвой баатрын хөшөөний санхүүжилт үлдэгдэл 5730.0 мянган төгрөг, Эрдэнийн шим ХХК-иас илүү суутгасан 30.3 мянган төгрөг, Ховд таван эрдэнэ ХХК-д 640.1 мянган төгрөгийн тус тус өртэй байна.

Тайлант үед үр дүнгийн тайланд нийт 1579251.5 мянган төгрөгийн орлого, нийт 1637756.5 мянган төгрөгийн зардал тайлагнасан нь хуримтлагдсан үр дүн дансыг (58505) мянган төгрөгөөр бууруулсан нь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс баталсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэн ажилласантай холбоотой байна.

Ховд Хөшөөт хөгжил сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 322379.0 мянган төгрөгөөр буюу 25.6 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт нь 2019 оны 4-р улирлын нүүрсний тооцоо болох 296194.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, 322902.0 мянган төгрөгийн Цэцэг сумын Хөшөөт багийн айл өрх албан байгууллагын цахилгаан хангамжийн ажлын санхүүжилтийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 202668.2 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь аймгийн ИТХ-аар хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээг 203376.6 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар, цалин, шимтгэлийн зардал 6868.1 мянган төгрөг буюу 24.7 хувь, хангамж бараа материалын зардал 1010.7 мянган төгрөг буюу 36.1 хувиар, Бараа үйлчилгээний бусад зардал 2952.5 мянган төгрөг буюу 109 хувиар, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардал 700.0 мянган төгрөг буюу 10.6 хувиар тус тус өссөн, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 11977.4 мянган төгрөгөөр буюу 45 хувиар буурсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2308300.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2308300.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

**Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд 2308300.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 67055.7 мянган төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс, 2241244.3 мянган төгрөгийг МоЭнКо ХХК-иас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр МоЭнКо ХХК-иас 1292026.9 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн дансаар төвлөрүүлж, 322902.0 мянган төгрөгийг МоЭнКо ХХК-иар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 ажлыг гүйцэтгүүлж нийт 1614928.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд өөрийн дансаар дамжуулан 1351446.3 мянган төгрөгийг зарцуулж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Цэцэг сумын Хөшөөт багийн айл өрх, албан байгууллагын цахилгаан хангамжийн 322902 мянган төгрөгийн ажлыг МоЭнКо ХХК-иар шууд гүйцэтгүүлсэн байна.

Төсвийн нийт орлогын гүйцэтгэл 1292026.9 мянган төгрөг буюу 55.9 хувь энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотой МоЭнКо ХХК-ны нүүрсний экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орсноор орлого тасарсан байна.

Зардлын хувьд 1351446.3 мянган төгрөг буюу 58.5 хувьтай байгууллага нь 526.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг 2021 оны төсөвт 526,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг дараа онд шилжүүлэн төлөвлөж, тайлант онд урсгал үйл ажиллагааны зардлаас цалин нэмэгдэл хөлсийг 683.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдаж 2311.8 мянган төгрөг, дотоод албан томилолт, зочид төлөөлөгч хүлээн авах зардлыг 2388.1 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 300.0 мянган төгрөг бүгд 5923.2 мянган төгрөг буюу 9.7 хувийг хэмнэн ажилласан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроож 4 мэдээлэл байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын зарим гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байсныг аудитын хугацаанд залруулан ажиллаа.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 65800.0 мянган төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад явуулсан боловч хэрэг нээх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна. Иймд уг авлагыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхээр албан тоотыг явуулсан байна. 15000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулан ажиллах албан шаардлагын биелүүлээгүй нүүрс хөтөлбөрийн мөнгөн хөрөнгийг аймгийн ЗДТГ-аас одоог болтол барагдуулаагүй байна.

**Хүснэгт 2.** Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 15000 | 0 | 0 | 1 | 15000 | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зөвлөмж | 1 | 68500 | 1 | 68500 | | | 100 |
| Нийт дүн | 2 | 83500 | 1 | 68500 | 1 | 15000 | 50 |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15000.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрч 15000.0 мянган төгрөгийн 1 алдаанд 1 төлбөрийн акт бичигдэж и баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг санхүүжүүлсэнтэй холбоотой 1 зөвлөмж өгөгдлөө.

- Илрүүлэлт: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг биелүүлээгүй одоог хүртэл аймгийн Засаг даргын тамгын газраас нүүрс хөтөлбөрийн хүрээнд гарсан 15000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулан ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

***<u>Залруулсан алдаа</u>:*** *Аудитаар залруулсан алдаа байхгүй болно*

**<u>Аудитын зөвлөмж:</u>** Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал нь байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. *Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал*

<u>1.1</u> *<u>Илрүүлэлт:</u>* Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

*<u>1.2</u> <u>Эрсдэл:</u>* Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

*<u>1.3</u> <u>Өгсөн зөвлөмж</u>:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

*<u>1.4</u> <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* Хүлээн зөвшөөрсөн

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| Огноо: | Аудитын нэр: | Ховд хөшөөт хөгжил сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| **2021** | | | ХОА-2021/36/СТА-ОНТС |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Ховд Хөшөөт хөгжил сан | Мянган төгрөгөөр |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Аймгийн ЗДТГ-т нүүрс хөтөлбөрийн мөнгөн хөрөнгө шилжүүлээд буцаан аваагүй, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг биелүүлээгүй. | 15000 | Төлбөрийн акт | Дарга<br>Нягтлан бодогч | Т.Мягмардорж<br>С.Оюунжаргал |
| 2 | Худалдан авалтуудыг И баримтаар баталгаажуулаагүй | 0 | Зөвлөмж өгөх | | |
| **ДҮН** | | **15000** | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**